

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2018 оны 10-12, 2019 оны 1-4 дүгээр сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар болон химийн аргаар тодорхойлж байна.

2018-2019 оны хүйтний улирал буюу 2018 оны 10-12 дугаар сар, 2019 оны 1-4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 21мкг/м³-ээр буюу 13%, хүхэрлэг хий 3мкг/м³-ээр буюу 9%-аар их, PM2.5 тоосонцор 12мкг/м³-ээр буюу 10%, азотын давхар исэл 2мкг/м³-ээр буюу 4%-аар тус тус бага байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2017 оны 10-12, 2018 оны 1-4 дүгээр сарын дундаж	2018 оны 10-12, 2019 оны 1-4 дүгээр сарын дундаж
PM10 тоосонцор	100	163	184↑
Хүхэрлэг хий, SO ₂	50	33	36↑
PM2.5 тоосонцор	50	119	107↓
Азотын давхар исэл, NO ₂	50	45	43↓

Улаанбаатар хотын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт харуулав.

PM10 тоосонцор




Зураг 1. Хүйтний улирлын PM10 тоосонцрын дундаж агууламж, 2011-2019 он

2018 оны 10-12, 2019 оны 1-4 дүгээр сарын агаар дахь PM10 тоосонцрын дундаж агууламжийг 2011-2012 оны мөн үетэй харьцуулахад 52%, 2012-2013, 2013-2014 онтой харьцуулахад 28%, 2014-2015 онтой харьцуулахад 3%-иар тус тус бага байсан бол 2015-

2016 оны мөн үетэй харьцуулахад 26%, 2016-2017 онтой харьцуулахад 9%, 2017-2018 онтой харьцуулахад 13%-иар их байна.


Харин Агаарын чанарын стандарт дахь Хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-тай харьцуулахад 2011-2012 онд 3.8 дахин, 2012-2013, 2013-2014 онд 2.6 дахин, 2014-2015, 2015-2016, 2016-2017, 2017-2018, 2018-2019 онд 1.5-1.9 дахин их байна (Зураг 1).



Зураг 2. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Энэ жилийн хүйтний улирлын PM10 тоосонцрын хамгийн их агууламж 1 дүгээр сард ажиглагдсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын дундаж агууламжийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 13мкг/м³-ээр буюу 5%-иар их, АЧС дахь ХА-тай харьцуулахад 2.5 дахин их байна (Зураг 2).

PM2.5 тоосонцор




Зураг 3. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын дундаж агууламж, 2011-2019 он

2018 оны 10-12, 2019 оны 1-4 дүгээр сарын агаар дахь PM2.5 тоосонцрын дундаж агууламж 2011-2012 оны мөн үеэс 25%, 2012-2013 оноос 17%, 2016-2017 оноос 19%,

2017-2018 оноос 10%-иар тус тус бага, 2013-2014 оноос 5%, 2014-2015 оноос 24%, 2015-2016 оноос 10%-иар их байна.


Хүйтний улирлын дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2011-2012 онд 2.8 дахин, 2012-2013 онд 2.6 дахин, 2013-2014 онд 2 дахин, 2014-2015 онд 1.7 дахин, 2015-2016 онд 1.9 дахин, 2016-2017 онд 2.6 дахин, 2017-2018 онд 2.4 дахин, 2018-2019 онд 2.1 дахин их байна (Зураг 3).



Зураг 4. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь PM2.5 тоосонцрын сарын дундаж хамгийн хамгийн их агууламж 2019 оны 1 дүгээр сард ажиглагдаж, 2018 оны мөн үетэй харьцуулахад 27мкг/м³-ээр буюу 12%-иар бага, АЧС дахь ХА-тай харьцуулахад 3.9 дахин их байна (Зураг 4).

Хүхэрлэг хий (SO₂)




Зураг 5. Хүйтний улирлын хүхэрлэг хийн дундаж агууламж, 2011-2019 он

2018 оны 10-12, 2019 оны 1-4 дүгээр сарын хүхэрлэг хийн дундаж агууламжийг 2011-2012 онтой харьцуулахад 33%, 2012-2013 онтой харьцуулахад 10%, 2015-2016 онтой харьцуулахад 32%, 2016-2017 онтой харьцуулахад 18%-иар тус тус бага бол 2013-2014,

2014-2015 оны мөн үетэй харьцуулахад 13%, 2017-2018 онтой харьцуулахад 9%-иар их байна.


Хүйтний улирлын дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2011-2012, 2015-2016 онд 1.1 дахин их байна (Зураг 5).



Зураг 6. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь хүхэрлэг хийн хамгийн их агууламж 1 дүгээр сард ажиглагдсан бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын дундаж агууламжийг 2018 оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй, АЧС дахь ХА-тай харьцуулахад 1.2 дахин их байна (Зураг 6).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 7. Азотын давхар ислийн хүйтний улирлын дундаж агууламж, 2011-2019 он

2018 оны 10-12, 2019 оны 1-4 дүгээр сарын азотын давхар ислийн дундаж агууламжийг 2011-2012 оны мөн үетэй харьцуулахад 22%, 2012-2013 онтой харьцуулахад 38%, 2013-2014 онтой харьцуулахад 16%, 2014-2015 онтой харьцуулахад 2%, 2016-2017 онтой харьцуулахад 10%, 2017-2018 онтой харьцуулахад 4%-иар тус тус бага, 2015-2016 онтой харьцуулахад 5%-иар их байна.

Хүйтний улирлын дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2011-2012 онд 1.1 дахин, 2012-2013 онд 1.4 дахин их байна (Зураг 7).



Зураг 8. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Энэ жилийн хүйтний улирлын азотын давхар ислийн хамгийн их агууламж 2019 оны 1 дүгээр сард ажиглагдаж, 2018 оны мөн үетэй харьцуулахад 5мкг/м³-ээр буюу 10%-иар их, АЧС дахь ХА-тай харьцуулахад 1.1 дахин их байна (Зураг 8).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС